



МОНГОЛ УЛСЫН
ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1998 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

ТУШААХ НЬ:

Гадаадад сургах тухай

1. Л. Сүхээг ОХУ-ын Москва хотын дотоод явдлын яамны академид удирдлагын мэргэжлээр 2 жил, А. Батсайханыг ОХУ-ын Москвагийн дипломатын академид олон улсын харилцааны мэргэжлээр 2 жил, Д. Алтанхоролыг Польш улсын Гданск хотын Анагаах ухааны академид 2 жил, Ө. Мөнхзулыг францын "НЕС" Их сургуульд менежментийн мэргэжлээр 1.5 жил, Л. Раднаабазарыг ХБНГУ-ын Гамбургийн Их Сургуульд хуулийн мэргэжлээр, Ө. Мөнгөнсарнай, Г. Билгүүн, Б. Алтанцэцэг нарыг АНУ-ын Ютагийн улсын коллежид бизнесийн удирдлагын мэргэжлээр тус тус 1998/1999 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчидын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сангийн захирал Б. Ганбатад, энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Водлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С. Алтангэрэлд тус тус даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ч. САЙХАНБИЛЭГ